

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗӨВЛӨХӨӨС БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ, АЖЛЫН ДААЛГАВАР

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, Гэрийн асрамж халамжийн үйлчилгээ, Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээ нь холбогдох хууль, тогтоомжид заасан зорилтот бүлгийн иргэдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлэх зорилготой нийгмийн халамжийн үйлчилгээ юм.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулахад тавигдах нөхцөл, шаардлагыг энэхүү ажлын даалгаварт тусгасан болно. Үүнд:

НЭГ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

- 1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас тухайн үйлчилгээний төрлөөр Магадлан итгэмжлэгдсэн байгууллага байх;*
- 2. Түр байрлуулан хамгаалах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлэх байгууллага нь Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл, гэрчилгээтэй байх;*
- 3. Үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн боловсон хүчин, ажилтнуудтай байх;*
- 4. Үйлчилгээ үзүүлэх багаж, тоног төхөөрөмж, эд хогшлоор бүрэн хангагдсан байх; /ТӨХ-т заагдсан багаж, тоног төхөөрөмж, эд хогшил гэх мэт/*
- 5. Байгууллага нь нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдэд үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх;*
- 6. Үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдэд ХХҮЕГ-ын даргын 2024 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан “Гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцох аргачлал”-д заасан үйлчилгээг чанартай, үнэн, зөв хүргэж, иргэдээс гарсан санал гомдлыг шийдвэрлэх боломжтой байх;*
- 7. Үйлчилгээ үзүүлэх боловсон хүчин нь ТӨХ-д заагдсан шаардлагыг хангаж байх ажлын туршлага, мэргэжлийн ур чадвартай байх;*
- 8. Үйлчилгээг хэт ачаалал үүсгэхгүйгээр батлагдсан хуваарийн дагуу хугацаанд нь чанартай сайн гүйцэтгэж, сар бүрээр тайланг гарган ирүүлдэг байх;*
- 9. Үйлчилгээг үзүүлэхдээ тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, бэлэн байдлыг хангаж ажиллах бүрэн боломжтой байх;*
- 10. Түр байрлуулан хамгаалах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байруулах үйлчилгээний хувьд “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS6040:2009 стандартыг хангасан байх;*
- 11. Үйлчилгээнд хамруулахын өмнө иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгнө.*
- 12. Тендерт оролцогч байгууллага нь үнийн санал ирүүлэхдээ үйлчилгээний нэр, төрөл тус бүрээр нэг бүрчлэн задалж, нийт багцын үнийн дүнг ирүүлнэ.*

ХОЁР. БОЛОВСОН ХҮЧНИЙ ШААРДЛАГА: Үйлчилгээ гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцөд тавих шаардлага:

№	Шаардлагатай боловсон хүчин	Ажилласан жил	Ажилтны тоо
Багц 1 Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд			
1	Сэтгэл зүйч	3 болон түүнээс дээш	1
2	Хуульч	3 болон түүнээс дээш	1
3	Нийгмийн ажилтан	3 болон түүнээс дээш жил	2
4	Үйлчилгээний ажилтан	1 болон түүнээс дээш жил	2
Багц 2,3 Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд			
1	Эмч	3 болон түүнээс дээш	1
2	Сувилагч	2 болон түүнээс дээш	1
3	Нийгмийн ажилтан	2 болон түүнээс дээш жил	1
4	Туслах ажилтан/жолооч, үйлчилгээний ажилтан/	1 болон түүнээс дээш жил	2
Багц 4-10 Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээнд			
1	Нийгмийн ажилтан	2 болон түүнээс дээш жил	1
2	Туслах ажилтан /жолооч, үйлчилгээний ажилтан/	1 болон түүнээс дээш жил	1
3	Үйлчилгээний ажилтан	1 болон түүнээс дээш жил	1

Гурав. Үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах багаж, тоног төхөрөмж, эд хогшлын жагсаалт:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг
Багц 1 Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд		
1	Эмнэлгийн анхны тусламж, үйлчилгээ үзүүлэх хэрэгсэл	1
2	Гал унтраах багаж хэрэгсэл	1
3	Гэгээлэг, дулаан уур амьсгал бүрдүүлсэн өнгө будалттай өрөө тасалгаатай, үйлчлүүлэгч, үйлчлүүлэгчийн амарч суухад хүрэлцээтэй тохилог сандал, ширээ, ор, ариун цэврийн өрөө, бусад хэрэгсэл бүхий орчны тохижилт хийгдсэн байна.	-
Багц 2,3 Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд		
1	Эмнэлгийн анхны тусламж, үйлчилгээ үзүүлэх хэрэгсэл	1
2	Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тээврийн хэрэгсэлтэй байх. /Бичиг баримтын хуулбарыг ирүүлэх/	1
Багц 4-10 Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээнд		
1	Эмнэлгийн анхны тусламж, үйлчилгээ үзүүлэх хэрэгсэл	1
2	Гал унтраах багаж хэрэгсэл	1
3	Гэгээлэг, дулаан уур амьсгал бүрдүүлсэн өнгө будалттай өрөө тасалгаатай, үйлчлүүлэгч, үйлчлүүлэгчийн амарч суухад хүрэлцээтэй тохилог сандал, ширээ, ор, ариун цэврийн өрөө, бусад хэрэгсэл бүхий орчны тохижилт хийгдсэн байна.	-

Дөрөв. Үйлчилгээг гүйцэтгэх хуваарь:

Багц 1: Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээг нийслэлийн иргэдэд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд үзүүлнэ.

Багц 2: Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг:

1. Баянгол дүүргийн 30 иргэнд 2024.03.15-2023.04.15-ны өдрийн хооронд;
2. Сонгинохайрхан дүүргийн 30 иргэнд 2024.05.01-2023.05.31-ний өдрийн хооронд;

3. Хан-Уул дүүргийн 30 иргэнд 2024.06.10-2023.07.09-ний өдрийн хооронд тус тус үзүүлнэ.

Багц 3: Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг:

1. Баянзүрх дүүргийн 30 иргэнд 2024.03.15-2023.04.15-ны өдрийн хооронд;

2. Сүхбаатар дүүргийн 30 иргэнд 2024.05.01-2023.05.31-ний өдрийн хооронд;

3. Чингэлтэй дүүргийн 30 иргэнд 2024.06.10-2023.07.09-ний өдрийн хооронд тус тус үзүүлнэ.

Багц 4-10: Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдралын итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээг харьяалал харгалзахгүйгээр зорилтот бүлгийн иргэдэд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд үзүүлнэ.

